

ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 03-р сарын 20-ны өдөр

Дугаар 03/05

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг
зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйлийн 60.2, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ хувьцаат компани (цаашид "Компани" гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.32.5 дахь хэсэг болон 7.34 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)-ийн 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид "Хурал" гэх)-ыг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 11 цагт Улаанбаатар хотод "Хасвуу" плазагийн хурлын танхимд хуралдуулсугай.

Хоёр. Хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй: (i) Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах; (ii) Компанийн 2023 оны үйл ажиллагааны үр дүнгээс ногдол ашиг хувиарлахгүй тухай гаргасан ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах; (iii) Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг кумулятив аргаар сонгох; (iv) Компанийн ТУЗ-ийн 2024-2025 оны ТУЗ-ийн цалин урамшуулал болон зардлыг батлах; (v) Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах.

Гурав. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 04 дүгээр сарын 09-ны өдрөөр тогтоосугай.

Дөрөв. Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх өдрийг 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөр тогтоон, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журамд нийцүүлэн хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.

Тав. Хувьцаа эзэмшигчид нь Компанийн 2023 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, 2023 оны үйл ажиллагааны тайлан, Компанийн 2023 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл болон холбогдох бусад мэдээлэлтэй танилцаж болно.

Зургаа. Хурлын даргаар Ц. Баярбаатарыг томилсугай. Тооллогын комиссын даргаар Г.Бэхбат, гишүүнээр М.Баярманла нарыг тус тус томилсугай.

Долоо. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудасны загварыг хавсралтаар баталсугай.

ДАРГА



Ц.БАЯРБААТАР